ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ УВС АЙМАГТ ТӨЛӨӨЛӨН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2025-12-09

| Д/Д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2025 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1.Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | | | | | | |
| 3.1.1 | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах | - | Угийн бичгийн хөтлөлтийн хувь | | Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна.<br><br>Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна | Монгол ахуй өв соёлоо дээдлэх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр бүлийн үнэт зүйлс, угийн бичиг хөтлөлт” сэдвээр Түргэн, Хяргас, Малчин, Давст, Сагил, Өндөрхангай, Зүүнхангай, Зүүнговь, Цагаанхайрхан, Тариалан сумууд болон НДГ, ХХҮГ-т сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн ирэх онд СУГ-тай хамтран угийн бичиг хөтлөлтийн багш бэлтгэх давтан сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Угийн бичгийн хөтлөлтийн хувь 9 байна.<br>Энэ нь өмнөх онтой харьцуулахад 2%-иар нэмэгдсэн байна. | Хэрэгжсэн |
| **3.1.2 Гэр бүлийн хүчирхийллийн талаар** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2.1 | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; | -<br>17,700.0 | 1. Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1<br><br>2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг зөрчлийн тоо бууралтын хувь | 2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийллийн тоо | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоож арилгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хэрэг, зөрчлийн тоо буурсан байна. | Цагдаагийн газартай хамтран зорилтот гэр бүлүүдэд зориулсан “Хайрлая. сонсъё” арга хэмжээг 4 удаагийн давтамжтайгаар 170 гэр бүлийг оролцуулан зохион байгуулсан. Мөн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үр хүүхдүүддээ зөв үлгэр дуурайлал үзүүлэх, зөв хандлагыг төлөвшүүлэх үүднээс 7 хоног бүрийн баасан гаригийг **“Гэр бүлийн боловсрол олгох цаг”** болгон зарласан. Үүний хүрээнд 7 хоног бүрийн баасан гаригт байгууллагын цахим хуудсанд гэр бүлийн холбогдолтой постер, рийл бэлтгэн тогтмол байршуулан олон нийтэд түгээн ажиллаж байна. Одоогийн байдлаар 11 төрлийн постер 11 төрлийн рийл оруулж 119.2 мянган хандалт авсан байна.<br>https://www.facebook.com/reel/627366210057671/?s=fb_shorts_profile&stack_idx=0<br>https://www.facebook.com/reel/4052640688304460/?s=fb_shorts_profile&stack_idx=0<br>https://www.facebook.com/reel/1017409753672585/?s=fb_shorts_profile&stack_idx=0<br>https://www.facebook.com/reel/1221116756047957/?s=fb_shorts_profile&stack_idx=0 | Хэрэгжээгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | https://www.facebook.com/reel/9109807719119938/?s=fb_shorts_profile&stack_idx=0<br>https://www.facebook.com/reel/667548372526972/?s=fb_shorts_profile&stack_idx=0<br>https://www.facebook.com/reel/1556776844992686/?s=fb_shorts_profile&stack_idx=0<br>https://www.facebook.com/reel/632489996616628/?s=fb_shorts_profile&stack_idx=0<br>2025 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хэрэг, зөрчил 155 гарсан нь гэр бүлийн хүчирхийллийн сургалт, сурталчилгааны үр дүнд энэ төрлийн зөрчлийн илрүүлэлт сайжирсан байна.<br>Нийт арга хэмжээний тоо 5 | |
| 3.1.2.2 | Гэр бүйин хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах; | | 1. Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийн бууралтын хувь | 2024 онд зохион байгуулсан сургалт нөлөөллийн ажлын тоо | Сургалт, мэдээлэл, сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулж хохирогчдод үзүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг зөрчил буурсан байна. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хүрээнд Увс аймгийн иргэдэд гэр бүлийн үнэ цэн, хосуудын үүрэг хариуцлагыг бэхжүүлэх сэтгэл зүйн боловсролыг соёл урлагаар дамжуулан олгох зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Гэр бүлийн нэгдсэн чуулган”-ыг Ойрад хөгжимт жүжгийн театрт 500 гаруй хосуудыг оролцуулан амжилттай зохион байгуулсан. Тус чуулганд Нийгэм судлалын дээд сургуулийн багш, докторант, МУУЗ багш | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Л.Бадамцэцэг, МУБИС-ын багш доктор, дэд профессор Д.Дэлгэрмаа нарыг урьж зочин багшаар оролцуулсан. Төрийн болон төрийн бус 25 байгуулагад сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. https://www.facebook.com/reel/1044326110910274/?s=fb_shorts_profile&stack_idx=0 https://www.facebook.com/reel/1003252078648718/?s=fb_shorts_profile&stack_idx=0 https://www.facebook.com/reel/2143030552882157/?s=fb_shorts_profile&stack_idx=0 Зорилтот гэр бүлүүдэд чиглэсэн гэр бүлийн хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх үүднээс Цагдаагийн газартай хамтран “Хайрлая сонсъё” арга хэмжээг 4 удаагийн давтамжтайгаар 170 гэр бүлийг оролцуулан зохион байгуулсан. Нийт 81 удаагийн сургалтаар 4175 иргэнд хүрч ажилласан. Үр дүнд: Гэр бүийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр нийт 81 сургалт мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулсанаар иргэдийн гэр бүлийн боловсрол нэмэгдэж, гэр бүлийн зөрил буурах үндэс болно. Нийт сургалтын тоо-81 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | https://www.facebook.com/photo.php?fbid=993311176316468&set=pb.100069127843346.-2207520000&type=3 https://www.facebook.com/photo.php?fbid=995449439435975&set=pb.100069127843346.-2207520000&type=3 https://www.facebook.com/photo.php?fbid=1139049601742624&set=pb.100069127843346.-2207520000&type=3 | |
| 3.1.2.3 | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагаа орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Гэр бүл, сэтгэлзүйн тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | - | Гэр бүлд үзүүлэх сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж чанар сайжирна. | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан гэр бүлийн боловсрол олгох, гэр бүл төлөвлөлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн анхан шатны зөвлөгөөг ганцаарчилсан байдлаар 591 иргэнд хүргэсэн. Үүнээс насанд хүрсэн 476 иргэн, 115 хүүхэд байх бөгөөд хүйсийн байдлаар ангилбал нийт үйлчлүүлэгчдийн 80 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хосын зөвлөгөөнд 4 гэр бүл хамрагдсан бөгөөд ихэвчлэн гэр бүлийн гишүүдийн харилцаа хандлагын талаар ойлголт зөрөлдөөнийг шийдвэрлэх асуудлаар хандаж үл ойлголцлыг давах арга зүйд суралцсан. | хэрэгжсэн |
| 3.1.2.4 | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал | Орон нутгийн төсвийн | Батлагдсан төсөв-100%<br><br>2.Зардлын | 2024 онд баталсан төсөв | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний | Орон нутгийн төсвөөс түр хамгаалах байрны ажилчдын цалин, урсгал зардлыг аймгийн ИТХ-н 2024 оны 12 сарын 16 ны 19 дүгээр тогтоолоор 146787000 төгрөгийг шийдвэрлүүлэн түр | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах; | хөрөнгөөр | хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-аас дээд түвшинд биелэх | | зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна.Хохирогчид үзүүлэх үйлчилгээний хүртээмж чанар нэмэгдсэн байна. | хамгаалах байрыг ажиллах боломжоор хanган ажилласан. 2025 онд түр хамгаалах байранд давхардсан тоогоор 79 хүүхэд, эмэгтэйчүүд үйлчилгээ авсан нь өмнөх онтой харьцуулахад 19 хувиар нэмэгдсэн байна. | |
| **3.1.3 Хүүхдийн эрхийн талаар** | | | | | | | |
| 3.1.3.1 | Хүүхдийн эрх хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх; | 1,835,234.8 | 1.Төлөвлөгөө баталсан эсэх<br>2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна. | Хүүхдийн төлөө зөвлөл, Хууль зүйн хорооны 2025 оны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувьтай байна. Хүүхдийн төлөө зөвлөл 13 байгууллага, Хууль зүйн хороо 11 байгууллагын бүрэлдэхүүнтэй хуралдаж 70 хувийн ирцтэй байсан.<br>Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан дараах онцлог ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Хүүхдийн байгууллагын үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, Увс аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг 12 төрлийн олон талт үйл ажиллагаа зохион байгуулсан. | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Увс аймгийн Хүүхдийн Зөвлөл, YOUTH POWER хүүхдүүдийн нэгдсэн чуулган зохион байгуулсан. Тус чуулганд 19 сум, 30 сургуулийн хүүхдийн төлөөлөл 150 хүүхэд оролцож хувийн 7 байгууллага, төрийн 6 байгууллага, сум орон нутгийн ЗДТГ,Хүүхдийн элч нар, ЕБС-иудын дэмжлэгээр зохион байгуулсан.<br>- Бүтэн өнчин хүүхдийн хадгаламж нээх арга хэмжээнд аймгийн 65 хүүхдийн судалгааг нэгтгэн хүргүүлж, Голомт банкинд хүүхэд тус бүрт 1,0 сая нийт 65,0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлж шийдвэрлэсэн.<br>Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны онцлог ажлын хүрээнд:<br>- Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг тогтоолгох шинжилгээнд 12 хүүхдийг хамруулсан.<br>- Гэмт хэргийн хохирогч гэрч сэжигтэн 21 хүүхдийн өмгөөлөгчийн зардалыг шийдвэрлэсэн.<br>- ХЧААХАвагдсан 9 хүүхдийг Зан үйлийг өөрчлөх сургалтанд хамруулж ялыг гүйцэтгэж байгаа бөгөөд 2025 онд 2 хүүхдийн хугацаа дуусаж 7 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхэд хамрагдаж байна. Нийтэд тустай ялаар шийтгэгдсэн 1 хүүхдийг нийгэмд тустай ажил хийлгэн ажилласан. | |
| 3.1.3.2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх | | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | 2024 онд хамрагдсан хүүхдийн тоо | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна. | Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлдэг Хүүхдийн ордон, ЕБС-ийн дугуйлан секц, Хүүхэд хөгжлийн төв, Хүүхдийн театр, бусад үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд байна. Үүнээс манай аймагт Хүүхдийн ордон-23, ЕБС-ийн дугуйлан секцэнд -1285, Хүүхэд хөгжлийн төвөөр-424, бусад -372, Хүүхдийн театр-10, нийт 2302 хүүхэд хамрагдсан байна. Увс аймгийн нийт 33000 гаруй хүүхдийн 6,9 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | Хэрэгжсэн |
| 3.1.3.3 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах | | Баталсан төсвийн хэмжээ | 2024 онд баталсан төсөв | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна. | ЭМСайд, БШУСайд, ХНХСайдын 2023 оны А/236, А189, А/80, хамтарсан тушаалаар батлагдсан “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ”-г хэрэгжүүлэхээр батлаж ирүүлсэн төлөвлөгөөний хүрээнд хүүхэд, гэр бүлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан 8 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.<br>Арга хэмжээний хүрээнд дараах онцлох ажлууд хийж гүйцэтгэсэн. Үүнд: | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг СӨБ-ийн байгууллагатай хамтран “Бага насны хүүхдийн цогц хөгжил" сургалт нөлөөллийн ажлыг 7 удаа 420 эцэг эх, асран хамгаалагч нарт зохион байгуулан ажилласан.<br>- Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлан таниулах хүрээнд аймгийн болон сумдын төрийн байгууллагын эцэг, эхийн зөвлөлүүдэд, сумдын хамтарсан багт Хүүхэд хамгааллын шинэчилсэн найруулгаар сургалт зохион байгуулсан.<br>- “Гэр бүл дэх хүүхдийн хөгжил”, “ Хүүхдэд ээлтэй орчин“ Бага насны хүүхдийг хүчирхийллээс хэрхэн урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвээр сургалт салбар бүрийн байгууллагын ажилтнууд, албан хаагчид, эцэг эхчүүдэд зохион байгуулсан.<br>Үр дүн: Аймгийн хэмжээнд нийт 116 байгууллага эцэг, эхийн зөвлөл байгуулсан. Хүүхэд хамгааллын бодлоготой 56, хүүхдийн өрөөтэй 15 байгууллага байна. Салбар бүрт хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус үйл ажиллагаанд төсөв санхүү тусгагдаагүй болно. | |
| 3.1.3.4 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах | | Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо<br><br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төг/ | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. | Байхгүй | Хэрэгжээгүй |
| 3.1.3.5 | Аймгийн хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангаж ажиллах | | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | | Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна. | Аймгийн хүүхдийн зөвлөл нь 4 дэхь удаагийн тэргүүнээ сонгож 40 гаруй тэргүүлэгч гишүүдтэй сум, сургуулийн 600 орчим гишүүнчлэлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тусгайлсан хурлын том заал, өрөө танхим байхгүй бөгөөд хүүхэд гэр бүлийн хөгжлийн газрын дэргэдэх unitel hub танхимд 7 хоног бүрийн 5 дахь өдөр хуваарийн дагуу үйл | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа явуулах боломжоор хангасан.<br>Хүүхдүүдийн дуу хоолойг сонсох, тэдний санал санаачлагыг шийдвэр гаргах түвшинд хүргэх хүүхдүүдийн хөгжил, хамгааллын хэрэгцээ шаардлагад тулгуурласан арга хэмжээг өрнүүлэх зорилгоор Хүүхдээ сонсъё аян, Хүүхэд-Хайр-Ирээдүй уриан дор Увс аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулан ажилласан. Үйл ажиллагааны хүрээнд:<br>-ЕБС-ийн түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх Чөлөөт индэр, VoiveBox саналын хайрцаг ажиллуулж сургууль бүрт өдөрлөг зохион байгуулсан.<br>-Цахим орчинд хүүхдүүдийн дуу хоолойг илэрхийлэх төрөл бүрийн рийл бэлтгэн АХЗөвлөлийн болон ХГБХХГазрын facebook хуудсуудаар олон нийтэд хүргэсэн.<br>-Хүүхдүүдийн оролцоог тэгш хангах зорилгоор сумын түвшинд, хөгжлийн бэрхшээлтэй, уралдаанч хүүхдүүд, малчин өрхийн хүүхдүүд, зусланд хамрагдсан хүүхдүүд, спортын болон олон нийтийн арга хэмжээнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдсан хүүхдүүдийг тусгай арга хэмжээний хүрээнд төлөөлөл болгон оролцуулж тэднийг сонсох ажлыг зохион байгуулсан. Увс аймгийн нэгдсэн чуулганаар аймаг, сумдын хүүхдүүдийн сургуулийн орчинд тулгамдаж буй асуудлыг сонсож, судалгаанд тулгуурлан илгээлт бичиг боловсруулж аймгийн төвийн 8 сургуулийн захирал, 19 сумын Засаг дарга нарт асуудлыг зохих түвшинд шийдвэрлүүлэхээр гардуулан өгсөн. Тус чуулганд аймгийн ЗДТГ, ХГБХХГ зэрэг төрийн байгууллагууд болон хувийн ААНэгж, банк санхүүгийн байгууллагууд дэмжлэг үзүүлэн ажилласан. | |
| 3.1.3.6 | "Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх | | 1.Олон нийтийн байцаагчийн тоо<br><br>2. Илрүүлсэн хүүхдийн тоо | - | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэгт өмнөх оноо 50 хувиар өссөн байна. | .Олон нийтийн байцаагч байхгүй. Увс аймгийн ХГБХХГазрын даргын 2025.08.12-ны өдрийн тушаалаар баталсан "Илрүүлье-Хамгаалья" аяны хүрээнд 18 сумаас 107 хүүхэд, ХНХЯ-ын 2025.10.05-ны өдрийн тушаалаар зарлагдсан "Асуудал-Шийдэл" аяны хүрээнд Улаангом сумын 108 хүүхдийг илрүүлж эрсдлийн түвшинг тогтоох түргэвчилсэн үнэлгээ хийж ажилласан. Тус үйл ажиллагааны хүрээнд 76 хүүхдэд шуурхай тусламжийн | хэрэгжээгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ, 12 хүүхдэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн байна. Тухайн хүүхдүүдийг эрсдлийн программд 100 хувь бүртгэсэн. | |
| **3.1.4. Хүүхэд хамгааллын талаар** | | | | | | | |
| 3.1.4.1 | “Хүүхэд хамгааллын бодлого”-ийг сурталчилан таниулж, салбар бүрд мөрдүүлэх | 403,907.9 | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо | - | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна. | Хүүхэд хамгааллын бодлогыг баталж эцэг эхийн зөвлөл байгуулсан 116 төрийн байгууллага ажиллаж байгаа бөгөөд нийт төр хувийн хэвшлийн байгууллагын 27 хувьд хүрсэн байна. Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо-56.<br><br>Эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Өндөрхангай, Зүүнхангай, Баруунтуруун, Зүүнговь, Түргэн, Сагил, Давст, Наранбулаг, Тариалан, Хяргас, Бөхмөрөн 11 сумдад Газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/19 дүгээр тушаалын дагуу Хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулын үйлчилгээний баг томилогдон ажилласан. | Хэрэгжсэн |
| 3.1.4.2 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин | | Эрсдэлт нөхцөлд байгаа | - | Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд | 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 380 хүүхэд, үрчлэгдсэн 51 хүүхэд, бүтэн өнчин 65 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 423 | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх | | хүүхдийн тоо | | үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | хүүхэд байна. Үүнээс бүтэн өнчин хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлж Засаг даргын тэтгэмжинд жил бүр хамруулж хүүхэд тус бүрт 1,0 сая нийт 65,0 сая төгрөгийн хадгаламж орон нутгийн сангаас шийдвэрлэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар хэлэлцүүлж гэр бүлд нь НБҮ хийж, хүүхэд бүрд хөгжлийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үрчлэгдсэн буюу хүнд нөхцөлд байгаа хараа хяналт сул хүүхдүүдэд авсан хүүхдүүдэд жилд 2 удаа буюу шинэ жил, хүүхдийн баяраар гэрээр эргэн хяналт хийж ажиллаж байна. | |
| 3.1.4.3 | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хувиарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хангах | | 1.Орон нутгийн төсвөөс хувиарласан төсөв<br>2.Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах | 26.7 Хувь | Хүүхдийн эрхийн хууль хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хамгааллын хариу үйлчилгээний хүрээнд 2025 он гарснаас хойш гэмт хэргийн хохирогч 18 хүүхдийн өмгөөлөгчийн зардал, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өмнөх оны 8, он гарснаас хойших 6, нийт 14 хүүхдээс 8 хүүхэд нь хугацаа нь дууссан буюу шилжсэн. Жил эцсийн байдлаар 6 хүүхдэд зан | хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | | | үйлд нөлөөлөх 130 цагийн сургалтыг явуулж сар бүр ШШГГазарт тайлагнаж байна. Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэж буй гэмт хэргийг хохирогч 11 хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг Ховд аймгийн бүсийн шүүх шинжилгээний төвд тогтоолгосон. Орон нутгийн төсвөөс 3,0 сая төгрөг төсөвлөсөн. Нийт 24 хүүхдээс 92 хувьд үйлчилгээ үзүүлсэн байна. Одоогоор жил дамжин үргэлжлэх шаардлагатай 2 хүүхдэд үйлчилгээг төлөвлөсөн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.4 | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих | | 1.Хяналт шалгалын тоо 2.Илрүүлсэн зөрчлийн тоо | | Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээ”-нд өөрчлөлт орсон. Тус тогтоолын дагуу өвөл хаврын хурдан морины уралдаанд 18 хүртэлх насны хүүхдийг аливаа хэлбэрээр оролцуулахгүй байхад аймгийн хэмжээнд хяналт тавьж Улаангом, Тариалан, Наранбулаг, Цагаанхайрхан сумдад хурдан морины уралдаан зохион байгуулахаар завдсан 6 удаагийн үйлдлийг мэдээллийн мөрөөр аймгийн Цагдаагийн газар, сумын хэсгийн төлөөлөгч, сумын хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар удаа дараа таслан зогсоож ажилласан. Үүнээс зөрчлийн шинжтэй 2 хэргийг шалган шийдвэрлэсэн.<br>Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/58 дугаартай “Увс аймгийн түүхт 100 жилийн ойн баяр наадмын хурдан морины уралдаанд хяналт тавих тухай” тушаал батлагдсан. Тушаалын хэрэгжилтийн хүрээнд газрын | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 54 алба хаагч хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавиж, ажилласан. Баяр наадмын хурдан морины уралдаанд нийт 694 хурдан морь уралдаж, давхардсан тоогоор 300 гаруй уралдаанч хүүхэд хурдан морь унасан байна. Даага насны морьдын уралдааны үед 1, Хязаалан 2, Соёолон 1, Азарга 1, Их нас 1, Сонгомол дээд 1, нийт 7 хурдан морины уралдаанч хүүхэд мориноос унасан бөгөөд 5 хүүхэд ямар нэгэн бэртэл гэмтэлгүй тул эцэг эх асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч 2 хүүхдийг Увс аймгийн Нэгдсэн эмнэлгээр дамжуулан эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг үзүүлсэн.<br>Нийт аймгийн хэмжээнд бүсийн 4, сумын ойн 7, сумдын баярын 11, аймгийн ойн 1, нийт 23 удаагийн хурдан морины уралдаанд хяналт тавьж хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилласан. | |
| 3.1.4.5 | Гамшиг онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний | | Үйлчилгээ авсан өрхийн тоо, | Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаала | Гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна. | Үер ус, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Онцгой байдлын газартай хамтран Гашууны гол, Увс нуур, Үүрэг нуур, Хяргас нуур гэсэн цэгүүдэд иргэдийн | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | | хүүхдийн тоо | л, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллааны нийтлэг шаардлага | | амралт зугаалганы үед хүүхдээ хамгаалах, сэрэмжлүүлэг, зөвлөмжүүд 100 гаруй иргэдэд түгээж, 4 самбар байршуулан ажилласан. Байгууллагын группээр дамжуулан 2 төрлийн постер түгээж 3200 гаруй хандалт авсан байна.<br>2025 онд Өндөрхангай, Наранбулаг 2 сумын 2 айлын гэр шатаж 6 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн бөгөөд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Улаанзагалмайн хорооноос хувцас хэрэглэл, хоол хүнс, Дэлхийн ОУБ-аас 1 гэр шийдвэрлэхэд холбон зуучилж хүүхэд хамгааллын зардлаас анхан шатны болон нэмэлт багц олгож шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлсэн. | |
| 3.1.4.6 | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай ажлыг зохион байгуулж, шаардалагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах, тэмдэг | | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | Цагдаагийн газартай хамтран "Насанд хүрээгүй хүнийг болзошгүй осол гэмтэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх" арга хэмжээний хүрээнд Улаангом сумын хэмжээнд байрлах нийтийн орон сууц, барилга, байгууламжийн орц хонгил, давхрын аюулгүй байдалд хяналт шалгалт хийж эрсдэлтэй 15 гаруй цэгийг илрүүлж аюулгүй байдлыг | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх | | | | | хангах хариу арга хэмжээ авч ажилласан.<br>Мөн хүүхдийн нийтийн тоглоомын талбайд ХЭУБайцаагчаар ахлуулсан ажлын хэсэг Цагдаагийн газар, Улаангом сумын багийн Засаг дарга нартай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж ажилласан. Хяналт шалгалтын хүрээнд Улаангом сумын Засаг даргад 1 удаагийн зөвлөмж хүргүүлж, газар дээр нь эрсдэлийг арилгуулж ажилласан.<br>Увс аймгийн түүхт 100 жилийн ойн хүрээнд бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгой байх, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх 2 төрлийн постер бэлтгэн түгээж, 2 телевизэр дамжуулан олон нийтэд суртадлчилсан. Мөн болзошгүй эрсдлээс сэргийлэх 10 гаруй төрлийн постерууд орц, дэлгүүр, худаг зэрэг олон нийтийн газарт байршуулж, нийгмийн ажилтнууд рийл бэлтгэн цахим сүлжээгээр түгээсэн. Эцэг эхчүүдэд урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх 2 удаагийн мэдээ бэлтгэн хүргэж, 4000 гаруй хандалт авсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.7 | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан байна. | - | Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна. | Хичээлээс гадуурх сургалтын төв-4, өдөр өнжүүлэх төв-1, сүм хийдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг -12 байгууллага, хүүхэд харах үйлчилгээний төв-1 цэгт, хүүхдийн зуслан -1 байгууллагуудад тус тус төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийж хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан.<br>Сүм хийдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 19 сумдын 12 сүм хийдэд 2 удаа хяналт, шалгалт зохион байгуулан судалгааг авч хяналт, шалгалтын явцад хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангаж хэрэгжүүлэн ажиллах талаар 1 зөвлөмж өгч ажилласан байна.<br>- Аймгийн хэмжээнд албан ёсны зөвшөөрөлтэй нийт 14 сүм хийд 4 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 12 сүм хийд нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж 2 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллага болон дангаараа хийж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч зөвлөмж хүргүүлэн ажилласанаар 12 сүм хүүхэд хамгааллын бодлоготой болж хэвшсэн шавилан суудаг 4 | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн эцэг, эхийн зөвшөөрөл хариуцлагын гэрээг хийж ажилласан бөгөөд хүүхдийн эрхийн зөрчил илрээгүй ба хэрэгжилт 100 хувьтай байна. | |
| **3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;** | | | | | | | |
| **3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар:** | | | | | | | |
| 3.2.1.1. | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | 2,867,810.7 | Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо | 2024 онд 17 салбарын 180 иргэн хамрагдсан | ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж , хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт хангаж ажиллах чиглэлээр 19 сумдын мэргэжилтнүүдээр дамжуулан нийт 55 аж ахуй нэгж, байгууллагын ажил олгогч, 882 ажилтан, албан хаагч, сумдын нээлттэй өдөрлөг, 2025 онд хэрэгжих хөтөлбөр, төслийн нээлтээр нийт 560 гаруй иргэнд мэдээлэл өгч ажилласан.<br>ААНБ-ын тоо-55<br>Хамрагдсан хүний тоо-1442 | Хэрэгжсэн |
| 3.2.1.2. | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих /хөдөлмөрийн | | 1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо | - | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын | Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ауйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд аймгийн хэмжээнд нийт 55 аж ахуй нэгж, байгууллагын 882 албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.<br>Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөх багштай | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | харилцааны хөтөлбөр/-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ; | | 2.Зохион байгуулсан сургалтын тоо | | ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна. | хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн тээврийн “Түмэнд нээлттэй хязгаарынхан” ХХК, шатахуун түгээх үйлчилгээ болон барилга угсралтын үйл ажиллагаа явуулдаг Ундарга Увс ххк, Хүнсний чиглэлээр үйл аиллагаа явуулдаг “Мөнхийн чанар ХХК” нийт 4 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, 90 гаруй ажилтныг сургалтад хамруулж хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний талаарх зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.<br>Сургалт- 8<br>Хамрагдсан ААНБ-59<br>Хувийн хэвшлийн 50-аас доош ажилтантай ААНБ-ын байгууллагын тоо-4<br>Хамрагдсан хүний тоо-972 | |
| 3.2.1.3. | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо 9 | Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна. | Улаангом сумын “Хөдөлмөрийн маргаан зохицуулах гурван талт хороо”-нд ирүүлсэн 12 иргэний гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд, шуурхай шийдвэрлэж ажилласан. Дээрх хөдөлмөрийн эрхийн маргаанд хамаарах 11 байгууллагын ажил олгогч, ажилтнуудыг хамруулан хөдөлмөрийн харилцааны асуудлаар нээлттэй ярилцлага өрнүүлж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. | хэрэгжээгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөдөлмөрийн харилцаанд үүсэж болох аливаа маргаанаас урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, чиглэл бэлтгэн 19 сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо-12 | |
| 3.2.1.4. | Аймаг, сумын хамтын хэлэлцээр байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах; | | Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо 0 | Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | “Улаангом дулааны 2 дугаар станц” ТӨХК-ийн 2025-2026 оны хамтын 1 гэрээг хянаж бүртгэсэн. | Хэрэгжсэн |
| **3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:** | | | | | | | |
| 3.2.2.1. | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | 2,812,759.2 | 1.Бодлогын баримт бичгийн тоо<br>2. Судалгаа, мэдээллийн тоо | Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна. | 2024 онд нийт 42.3 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулснаас дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 17.9 тэрбум, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 14.7 тэрбум, уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарт 9.7 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан бөгөөд Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо 2024 онд 849 байна. Гол нэрийн бүтээгдэхүүнүүдээс дурдвал чацарганы тосны үйлдвэрлэл 35.36 хувиар, жимсний шүүсний | хэрэгжээгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрлэл 58.9 хувиар, гурилын үйлдвэрлэл 29.8 хувиар тус тус буурсан бол талх 29.7 хувиар, нарийн боов 61.6 хувиар, архины үйлдвэрлэл 52.2 хувиар, цэвэршүүлээгүй алт 3.6 дахин, чулуун нүүрс 40.2 хувиар, дулаан үйлдвэрлэл 18.8 хувиар тус тус өссөн байна. | |
| 3.2.2.2. | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болгох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах; | - | Судалгаа, мэдээллийн тоо | Албан ёсны статистик судалгаа (Ажиллах хүчний судалгаа)<br><br>Хөдөлмөр эрхлэлийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн EJOB систем | Аймгийн/сум тус бүрээр/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна. | Сумдын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон багийн нийгмийн ажилтнуудтай хамтран Улаангом сумын 12 баг болон 18 сумын ажиллах хүчний нарийвчилсан судалгаа авч, нэгтгэн ажиллалаа.<br>Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн сан ejob системд 1850 ажлын байрны захиалга, 1200 ажил зуучлал, 1200 шинэ ажлын байр бүртгэн, мэдээллийн санд шивэлт хийж ажиллалаа.<br>Хэрэгцээтэй хүний нөөцийн мэдээг голлох салбараар авч үзвэл:<br>Хөдөө аж ахуйн салбарт 112, боловсруулах үйлдвэрт 89, барилгын салбарт 73, үйлчилгээний бусад салбарт- 65 ажилтан хэрэгцээтэй байна. Мөн хэрэгцээтэй хүний нөөцийн тоон мэдээг мэргэжлээр авч үзвэл: Менежер-16, Мэргэжилтэн-32, Техникч болон туслах -43, | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Контор үйлчилгээний ажилтан-18, Худалдаа үйлчилгээний ажилтан-33, Хөдөө аж ахуйн салбарт- 112, Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан-73, Машин механизмын операторч, угсрагч-12 хэрэгцээтэй байна. Судалгаа, мэдээллийн тоо-12 | |
| 3.2.2.3. | Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | - | 1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь<br><br>2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь | Хөдөлмөр эрхлэлт ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл | Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Аймгийн шилдэг Старт ап залуучуудын багийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж нийт 26 багийн 62 залуу бүртгүүлэн 72 цагийн сургалтад сууж, 7 баг хурдасгуур хөтөлбөрт хамрагдан Чацарганын тостой уруул өнгөлөгч төслөөр "Rainbow" баг, Хувцас загварын чиглэлээр "Уламжлалаа амьдруулья" баг ууд шалгарч тус бүр 15,0 сая төгрөгийн 50 хувийн эргэн төлөлттэй 3 жилийн хугацаатай санхүүгийн дэмжлэгт хамрууллаа. Ховд аймагт болсон Баруун бүсийн Шилдэг старт ап-2025 шалгаруулах арга хэмжээнд Увс аймгаас 5 баг оролцож финалын шатанд 2 баг шалгарч амжилттай оролцлоо.<br>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 19 сумын 60 ахмадыг хамруулж 300,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож үр дүнд нь | хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3.Аймгийн ажилгүйдэл ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь | | | байнгын ажлын байр 60 бий боллоо.<br>Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, болон хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 72 ахмадыг хамруулж түр ажлын байраар хангаж ажиллалаа.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт Увс аймгийн 19 сумын 40 иргэнийг хамруулж 200,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож үр дүнд нь байнгын ажлын байр 40 бий боллоо.<br>"Эм эс девелопмент консалтинг" ХХК-ны дэргэдэх мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран “Бизнес санаа хөгжүүлэх, төсөл хэрэгжүүлэх” сургалтад 20 иргэнийг хамруулж 780.000 төгрөг зарцууллаа.<br>Эмэгтэйчүүдийн зайнаас ажиллахыг дэмжих цахим ур чадвар олгох цахим сургалтыг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт судалгааны хүрээлэнтэй хамтран зохион байгуулж 113 эмэгтэйг хамруууллаа.<br>Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2025 оны 03 улиралын байдлаар 66.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.6 функтаар буурсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2.4 | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачлагыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах; | | 1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2. Холбогдох, арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо-48 Холбогдох, арга хэмжээний тоо-4 Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ-240 сая | Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. | Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хүрээнд:<br>Байнгын ажлын байранд зуучилсан иргэдийн тоо - 153<br>Түр ажлын байранд зуучилсан иргэний тоо - 371<br>Төсөл хөтөлбөрт хамрагдсан өрх иргэн – 43<br>Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо-171, түр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо- 371,<br>Арга хэмжээний тоо-4<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ 534 сая | хэрэгжсэн |
| 3.2.2.5. | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнйи төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | - | 1.Ажилд зуулчлуулсан иргэний тооны өсөлт 2.Холбогдох арга хэмжээ тоо | - | Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийн байгуулах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн 1 давхарын 5 өрөөг засварлаж дуусгасан.<br>"Ундармал оюун ухаан" НҮТББ-тай хамтран бүлгийн чиг баримжаа зөвлөгөө, мэдээллийг 30 бүлгийн ажил хайч 450 гаруй иргэнд 8,1 сая төгрөг зарцуулсан. | хэрэгжсэн |
| 3.2.2.6. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын | - | Хөтөлбөрийн хэрэгжилт, сангийн хөрөнгийн зарцуула | - | Хөтөлбөрийн хэрэгжилт, сангийн хөрөнгийн | Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт хийж ажиллалаа.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу зарцуулж байгаа эсэх , ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | лтад хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байх Зөвлөмжийн тоо | | зарцуулалтад хяналт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна. | хөтөлбөрт 18 иргэнд 90 сая төгрөг, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 36 ахмад настанд 180 сая төгрөг, малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт 36 малчинд 288 сая төгрөг, санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 42 иргэнд 210 сая төгрөг олгож журмын дагуу зарцуулсан байна. Нийт 768 сая төгрөг олгож 132 ажлын байр бий болсон байна.<br>Газрын даргын А/50 дугаар тушаалаар ХЭДСангийн зээлийн хугацаа хэтрэлттэй иргэдийн эргэн төлөлтийг төвлөрүүлэх ажлын хэсэг байгуулан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.Үүнд: Дотоод хяналтын ажлын хэсэг сумдад 2 удаа ажиллаж хугацаа хэтсэрсэн иргэдэд мэдэгдэл өгч ажилласан.<br>Шүүх прокурорын байгууллагад нийт 261 иргэнийг шилжүүллээ. Үүнд:<br>✓ Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд хамрагдсан 90 иргэн<br>✓ Малжуулах арга хэмжээнд хамрагдсан 61 иргэн, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сум дундын анхан шатны шүүхэд:<br>✓ Ахмадын санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдсан 59 иргэн,<br>✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 51 иргэнийг хүргүүлж хамтран ажилласан байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2015-2022 онд хэрэгжиж хугацаа дууссан төсөл хөтөлбөрүүдийн эргэн төлөлтийн хугацааг тооцож 215 иргэний 241 сая төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлж, 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 1,213,909,117 төгрөг төвлөрүүлж ажиллалаа.<br>Хяналтын тоо: 3<br>Зөвлөмжийн тоо:3 | |
| 3.2.2.7 | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон | - | 1. Холбогдох арга хэмжээний тоо<br>2.Арга хэмжээнд хамрагдс | 2024- онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт | Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй | Аймгийн шилдэг Старт ап залуучуудын багийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж нийт 26 багийн 62 залуу бүртгүүлэн 72 цагийн сургалтад сууж, 7 баг хурдасгуур хөтөлбөрт хамрагдан Чацарганы тостой уруул өнгөлөгч төслөөр "Rainbow" баг, | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | | ан хүний тоо 3.Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо | 1 багийг хамруулж, 10 сая төгрөг зарцуулсан. | эрхлэгч нэмэгдсэн байна. | Хувцас загварын чиглэлээр "Уламжлалаа амьдруулья баг ууд шалгарч тус бүр 15,0 сая төгрөгийн 50 хувийн эргэн төлөлттэй 3 жилийн хугацаатай санхүүгийн дэмжлэгт хамруулллаа.<br>Ховд аймагт болсон Баруун бүсийн Шилдэг старт ап-2025 шалгаруулах арга хэмжээнд Увс аймгаас 5 баг оролцож финалын шатанд 2 баг шалгарч амжилттай оролцлоо.<br>Арга хэмжээний тоо: 2<br>Хүний тоо: 2 баг, 4 залуу<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ:30 сая<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлд 2025 онд зээлийн эргэн төлөлтөөс ХААН банкаар дамжуулан хувиараа хөдөлмөр эрхлэгч 1 иргэнд 10,0 сая төгрөг, Төрийн банкаар дамжуулан хувиараа хөдөлмөр эрхлэгч 1 иргэнд 10,0 сая төгрөгийг тус тус олголоо<br>Арга хэмжээний тоо: 1<br>Хүний тоо: 4<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ:20 сая | |
| 3.2.2.8 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд | - | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдс | 2024- онд ХЭДС-аас борлуулалтын | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн | "УВСАД ҮЙЛДВЭРЛЭВ" борлуулалтын түрээсийн төлбөрт 14,4 сая төгрөг зарцуулсан. Тус төвөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан 46 | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | борлууллалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулаж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах; | | ан хүний тоо<br>2. Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ | дэмжлэгт 68 хүн хамрагдаж 10,8 сая төгрөг зарцуулсан. | борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | иргэний 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулагдаж байна. Борлуулалтын цэгүүд нь сард дунджаар 16,1 сая төгрөгийн борлуулалт хийгдэж байна.<br>Хамрагдсан хүний тоо: 46<br>Хөрөнгийн хэмжээ: 14,4 сая | |
| 3.2.2.9 | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах; | - | Холбогдох арга хэмжээний тоо | 2024 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд 8 сая төгрөг зарцуулсан. | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна. | Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдөр хуралдаж, хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2025 оны 1 дүгээр тогтоол, ХНХЯ-ын сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/50 дугаар тушаалыг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулах төсвийг сумдын хүн амын тоо, онцлогт нийцүүлэн баталж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа.<br>Зарцуулсан төсөв: 2,5 сая | хэрэгжсэн |
| 3.2.2.10. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн | | 1.Төлөврүүлсэн хөрөнгийг хэмжээ<br>2.Хөдөлмөр | 024 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй 1 аж | Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөө гарган, холбогдох байгууллагуудад албан бичиг илгээж, 49 байгууллагын судалгаа гаргаж нэгтгэлээ. Тус | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах ; | - | эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | ахуйн нэгж, байгууллагаас ХЭДС-нд 2.6 сая төгрөг төвлөрүүлсэн. | бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 49 байгууллагад 71 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, эрх зүйн зохицуулалтыг хангуулах тухай хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 12 заалт бүхий 02 дугаар зөвлөмжийг 150 аж ахуй нэгж, байгууллагад хүргүүлж ажиллалаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-144.3 дахь хэсгийн хүрээнд 2 аж ахуй нэгж, байгууллагын 80 гаруй албан хаагчид сургалт мэдээлэл хийж, 4 төрлийн шторк бэлтгэж цахим сүлжээнд байршуулж сурталчиллаа.<br>ХЭДС-нд 1.6 сая төгрөг төвлөрүүлсэн.<br>аас дээш ажилтантай төрийн болон төрийн өмчит газар, ААН байгууллагын судалгааг гарган, нийт 18 байгууллагад хуулийн хэрэгжилт хангаж ажиллах тухай зөвлөмж боловсруулж хүрүүлсэн. | Хэрэгжсэн |
| **3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.3.1. | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх. | - | Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна. | 2025 онд ОН-аас төсөв тавигдаагүй. | хэрэгжээгүй |
| 3.2.3.2. | Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөлөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Төлөвлөсөн төсөв<br><br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 онд нийт 45 байгууллагын 640 гаруй ажилтан албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан зохион байгуулса | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран "Хиймэл оюун ухаан ба цахимжилт" сарын аяны нээлтийг 2025.04.04-ны өдөр зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд 15 байгууллага аж ахуй нэгж, 350 иргэн оролцлоо.Сарын аяны хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийн хүрээнд бүх шатны удирдлагын манлайллыг хангах, ажилтан бүрийн мэдлэг, хандлага, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Аймгийн Нийгмийн даатгалын газар, Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 3 удаагийн сургалт, зөвлөгөөн, | хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | н арга хэмжээ 6 | | хяналт шалгалтын ажлыг хамтран зохион байгуулж, аймгийн хэмжээнд 55 аж ахуй нэгж, 882 ажилтан албан хаагч оролцлоо.<br>Гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдлээс сэргийлэх, ажлын байрны хөдөлмөрийн болон ахуйн нөхцлийг сайжруулах талаарх цахим контент бэлдэж нийтэд сурталчилж, аймгийн хэмжээнд төрийн тусгай 2, төрийн захиргааны 3, төрийн үйлчилгээний 8 байгууллага, аж ахуй нэгж байгууллага 12, нийт 25 байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2025 оны төлөвлөгөө, үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. 19 сумын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалт цахимаар зохион байгууллаа. Сургалтад урилгаар ХХҮЕГ-ын Хөдөлмөрийн хяналтын Улсын Ахлах байцаагч Д.Баасандорж мэдээлэл өгч, Увс аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагч Д.Цэнд-Аюуш, Аймгийн ҮЭХ-ны тэргүүлэгч Д.Энхтуяа нар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл өгч ажиллалаа. Цахим сургалтад 18 сумын ХАБЭА-н зөвлөлийн дарга, гишүүд нийт 90 гаруй албан хаагч хамрагдлаа.<br>Увс аймгийн Засаг даргын тамгын газрын шийдвэрийн дагуу өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах ажлын хэсэг 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 15-ны өдрийн хооронд Сагил сумын таван багийн иргэд, малчидтай уулзалт зохион байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Увс аймгийн ХАБЭА-н салбар зөвлөлийн гишүүн Д.Дашдаваа уулзалтад оролцсон иргэд, малчид, даатгуулагчдад хууль тогтоомж сурталчлан дараах асуудлын хүрээнд мэдээ, мэдээлэл хийж, асуусан асуултад дэлгэрэнгүй хариулт өгч ажиллалаа.<br>Үүнд:<br>- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн ойлголт, шимтгэлийн төрөл, хувь хэмжээ<br>- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарим зүйл, малчдад хамааралтай асуудлууд<br>- -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт, хамаарах асуудал<br>- Сумын ҮОХХ-ыг судлан бүртгэх комиссыг байгуулах, түүний бүрэлдэхүүн, авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг сэдвээр мэдээлэл өгч ажиллалаа.<br>Сагил суманд хийсэн уулзалтад оролцсон иргэд, малчид, даатгуулагчдын тоо<br>✓ 1-р баг, Баянзүрх – 40 иргэн<br>✓ 2-р баг, Боршоо - 52 иргэн<br>✓ 3-р баг, Өндөр мод – 80 гаруй иргэн<br>✓ 4-р баг, Үүрэг нуур - 53 иргэн<br>✓ 5-р баг, Хар мод – 48 иргэн<br>Нийт – 273 иргэн<br>Аймгийн ХХҮГ-ын мэргэжилтэн, улсын байцаагч нар аймгийн Музейгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 20 албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгууллаа. Хөдөлмөрийн хяналтын байцаагч, Хөдөлмөрийн харилцаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нар аймгийн хэмжээнд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 13 аж ахуйн нэгж байгууллагуудад аюулгүй ажиллагааг ханган ажиллах тухай хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагчийн зөвлөмж, ХАБЭА-н тухай хуулийн талаарх гарын авлагыг тарааж ажиллалаа.<br>ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ГБХНХЯ-ны сайдын 2025 оны 02 дугаар сарын 05 ны өдрийн албан даалгаврын хэрэгжилтийн 1,2,3,4 дүгээр улирлын тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.<br>Арга хэмжээний тоо-10<br>ААНБ тоо: 128<br>Хүний тоо:1620 | |
| 3.2.3.3 | Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрийн томоохон осол, хурц | Орон нутгийн төсвий | Төлөвлөсөн төсөв Тухай бүр авсан | 2024 оны гүйцэтгэл | Тухай бүр арга хэмжээ авсан байх | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулах зорилгоор 3 төрлийн цахим контент бэлтгэн орон нутгийн телевизүүд болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан ажил олгогч, иргэдэд хүргэж ажиллалаа. Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах” тухай 12 | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг асран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээ авах; | н хөрөнг өөр | арга хэмжээни й тоо | | | заалт бүхий зөвлөмжийг боловсруулан хүргэж “Аюулгүй барилга-аюулгүй ажиллагаа ” сарын аяны хүрээнд нийт 14 аж ахуй нэгжийн барилга угсралтын үйл ажиллагаатай танилцан, холбогдох зөвлөмж, шаардлагын тавьж, аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор ХАБЭА-н сургалтын тусгай зөвшөөрөлтэй сургалтын байгууллага болох “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны эрдэм шинжилгээний сургалт судалгааны төв” ТББ хамтран ажиллалаа. Тус сургалтаар ХАБЭА, нийт ажилтны сургалтад нийт 40 гаруй байгууллагын удирдах ажилтан, 2 байгууллагын нийт 111 ажилтныг хамрууллаа. Увс аймгийн түүхт 100 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан 2025 оны 7 дугаар сарын 19-нд аймгийн хэмжээнд худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлдэг 300 аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлд Улаангом сумын ЗДТГ-тай хамтран иргэдэд эрүүл аюулгүй хоол хүнсээр үйлчлэх, өөрсдийн аюулгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаа хангаж ажиллах, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд үйлдвэрлэл үйлчилгээг хэрхэн явуулах талаарх сургалтыг зохион байгуулж тус тус ажиллалаа.<br>Салбарын улсын ерөнхий байцаагчийн 08/07/02, 08/07/16 удирдамжийн дагуу Боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналтад 3 аж ахуйн нэгжийг хамруулан албан шаардлагыг хүргүүлэн зөрчлийг арилгуулан ажиллалаа. Мөн хүүхдийн хийлдэг тоглоом ажиллуулж байгаа 6 иргэнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, хүүхдийн тоглоомын стандартын талаар мэдээлэл өгч тус тус ажиллаж байна.<br>Мөн түүнчлэн барилгын салбарын аюулгүй ажиллагаатай холбоотой шторк бэлтгэн орон нутгийн телевизүүд болон цахимаар тогтмол мэдээлж ажиллаж байна.<br>Арга хэмжээний тоо: 9 | |
| **3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:** | | | | | | | |
| | | | 1.Хөдөлм өр эрхлэх | | | Тариалан суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Жинэст өргөө ХХК-д хятад улсын 5 иргэн, Увс | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.4.1. | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2. Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ 3. Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллгын монгол гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт | 2024 онд Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 46 | Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | нуурын чиглэлийн авто зам тавих ажилд гадаадын хөрөнгө оруулалттай Эйч Кэ Би Интернэшнл холдинг ХХК-д 89 хятад улсын иргэн, Наранбулаг сумын харгантын хүдрийн уурхайд гадаадын хөрөнгө оруулалттай Эй Эл Жи Ти ХХК-д хятад улсын 11 иргэн нийт 105 гадаадын иргэн ажиллаж 166 320 000 төгрөгний ажлын байрны төлбөр төлүүлсэн байна.<br>Гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай Салбарын ерөнхий байцаагчийн 08-07/16 дугаартай удирдамжийн дагуу 2025 оны 08 сарын 12-аас 08 сарын 14-ны хооронд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^2$ дугаар зүйл, Гэр бүл хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн 07.1.1 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудсыг ашиглан Гадаадын иргэн харьяатын газартай хамтран хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ.<br>1. Улаангом сумаас Увс нуур чиглэлийн хатуу | хэрэгжээгүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хучилтай Авто замын барилгын ажлыг гүйцэтгэж байгаа Эйч Кэ Би Интернэшнл ГХОХХК нийт 90 ажилтантай эрэгтэй 85, эмэгтэй 5 гадаад ажилтан 85<br>2. Увс аймгийн Наранбулаг сумын Алдар багт хүдрийн уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Эй Эл Жи Ти ГХОХХК нийт 21 ажилтантай эрэгтэй 17, эмэгтэй 4 гадаад ажилтан 14<br>Хяналтаар визний ангилал хөдөлмөр эрхлэх, Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон.<br>Ажил олгогч гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлсний төлөө гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлсөн Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл ажил олгогчийн сонгосон гадаад ажилтны овог, нэр, иргэний харьяалал, хөдөлмөр эрхлүүлэх хуулийн этгээдийн нэр, хөдөлмөр эрхлэх байршил, зөвшөөрлийн хугацаа зэрэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл тохирсон ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулсан эрх нь зөрчигдөөгүй байна.<br>Гадаад ажилтны тоо-105<br>Хяналт шалгалтын тоо-2<br>Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ-166 320 000 | |
| 3.2.4.2 | Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | | | Хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж буй 3 аж ахуй нэгж байгууллагад ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн зөвлөгөө мэдээлэл өгч тус хуулийн 22.4 дэх заалтыг мөрдөн ажиллахыг зөвлөсөн.<br>Салбарын ерөнхий байцаагчийн 08-07/16 дугаартай удирдамжийн дагуу хяналт шалгалтаар<br>1. “Эйч Кэ Би Интернэшнл” ГХОХХК хууль сахин мөрдөлт 85% эрсдэл үүсэх магадлал бага<br>2. Эй Эл Жи Ти ГХОХХК хууль сахин мөрдөлт 91% эрсдэл үүсэх магадлал бага<br>Гадаад ажилтны ажлын байр нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасан ажлын байрны төрөл, ангилалд нийцсэн байна.<br>Зөвлөгөө мэдээллийн тоо-3<br>Хяналт шалгалтын тоо-2 | Хэрэгжсэн |
| **3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | | | | | | |

| 3.3.1 Нийгмийн даатгалын талаар: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.1.1 | Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах | 2 006 174.1 | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь | Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023 он-152 800, Увс аймгийн хэмжээнд сайн дараар даатгуулагчийн тоо 2024 он - 4366 | Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэдийн нийгмийн даатгалын тухай ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор сумдын байцаагч нар малчидтай гэрт нь очиж мэдээлэл хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр мэдээлэл түгээх гэх мэт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд 58 удаагийн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулж, 286 аж ахуйн нэгж 3942 иргэнд мэдээлэл хүргээд байна.<br>Эдгээр ажлуудын үр дүнд 2025 оны жил эцсийн байдлаар нийт 4029 малчин, бусад сайн дурын 1350 даатгуулагч, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эцэг 125 даатгуулагч, 0-3 насны хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх 502 даатгуулагч, нийт 6006 даатгуулагчийг хамруулж сайн дурын даатгалын жилийн хамралтын төлөвлөгөө 99.2%-иар биелүүлээд байна. | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Увс аймгийн хэмжээнд сайн дараар даатгуулагчийн тоо 5753 | |
| 3.3.1.2 | Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | | Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь | - | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | "Дижитал Увс аймаг" төслийн хүрээнд 2023 онд тэтгэврийн хувийн хэрэг цахимжуулах 7.5 сая төгрөгийн программ хангамжийг аймгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан. Аймгийн хэмжээнд 13500 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг скайнердаж, цахимжуулах програмд 13480 тэтгэвэр авагчийн хувийн хэргийн 388619 файлын нэг бүрчлэн шивж оруулах ажлыг 100% хийж гүйцэтгэсэн.<br>2025 онд шинээр тогтоосон 416 тэтгэврийн хувийн хэргийг тухай бүр цахим системд бүртгэж бүрэн цахимжуулсан.<br>Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | хэрэгжсэн |
| 3.3.1.3 | Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн | | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо | Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо - 848, Увс аймгийн хэмжээнд өртэй төсөвт | - | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын өр авлагын талаар сар бүр нягтлан бодогч нартай тооцоо нийлж, мэдээлэл хүргэн хамтран ажиллаж байна. Мөн салбар салбарын чиглэлээр хариуцдаг дээд байгууллагуудад нь албан тоот хүргүүлсэн. Тухайлбал, эрүүл мэндийн салбарын | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх | | | байгуулла гын тоо - 29 | | байгууллагуудын шимтгэлийн өрийн жагсаалтыг аймгийн Эрүүл мэндийн газарт, боловсролын байгууллагуудын шимтгэлийн өрийн мэдээллийг аймгийн Боловсролын газарт, мөн аймгийн Төрийн сангийн хэлтэст төсөвт газруудын шимтгэлийн өрийн мэдээллийг хүргүүлж, барагдуулах талаар мэдээл өгч хамтран ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн шимтгэлийн авлага 1084.0 сая төгрөгийн авлагаас тухайн тайлант 2025 онд 736.2 сая төгрөгийн авлага буюу оны эхний хуримтлагдсан авлагаас 67.9 хувийг барагдуулсан.<br>Шимтгэлийн өртэй аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг 4 ангилалаар гаргаж холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаллаа. Үүнд,<br><br>1. Найдваргүй өртэй 34 байгууллага байгаагаас тайлант хугацаанд 9 ажил олгогчийн 12.9 сая төгрөгийн өрийг бүрэн, 2 ажил олгогчийн 12.8 сая төгрөгийн өрийг хэсэгчлэн, нийт 25.7 саяя төгрөгийн найдваргүй өрийг барагдуулж ажиллалаа. 3 ажил олгогчийг шүүхэд, 1 жил олгогчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд тус тус шилжүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн 11 байгууллагаас 2 аж ахуйн нэгж байгууллагын 13.0 сая төгрөгийг барагдуулж ажиллалаа.<br>3. Үйл ажиллагаа зогссон, оршин байгаа хаяг тодорхойгүй, хариуцах эзэн холбогдогч сураггүй болсон, нас барсан, хуулийн этгээд татан буугдсан болон дампуурсан 11 аж ахуйн нэгж байгууллагын 12.7 сая төгрөгийн шимтгэлийн авлагын судалгааг НДЕГ-т хүргүүлсэн.<br>4. Идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 402 аж ахуйн нэгжийн судалгааг гарган авлагын насжилтаар ангилж нийт 115 ажил олгогчид холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд, 31 албан шаардлага, 51 данс хаах мэдэгдэл, 9 өр барагдуулах гэрээ, 9 шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, 13 эвлэрүүлэн зуучлагчаар эвлэрсэн, 2 уулзалтын тэмдэглэл хөтөлсөн зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.<br>Үүний үр дүнд нийт 736.2 сая төгрөгийн авлага барагдсан. | |
| 3.3.1.4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчпүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн | | Хөдөлмөрийн чадвар алдсан | Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвараа | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулах | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, иргэний | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хзрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах; | | иргэдийн тоо | алдсан иргэдийн тоо - 102446, Увс аймгийн хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн тоо - 3293 | | хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагааг ижил түвшинд хүргэх зорилготойгоор ижил мэргэжилтний үзлэгийг, мөн сайн туршлага солилцох ажлыг тэргүүлэх өвчлөл болох дотрын өвчнийг сонгон Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 05 сарын 13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2025 оны 05 сарын 30-ны өдөр магадлагч эмч, ЭММЗ-ийн дотрын эмч Аймгийн нэгдсэн эмнэлэгийн дотрын 8 эмчтэй хамтран зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан. Мөн Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн 2025 оны 06 сарын 06-ны өдөр баталсан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд ижил мэргэжилтний үзлэгийг цахимаар зохион байгуулах удирдамжийн дагуу магадлагч эмч, төрөлжсөн 3 мэргэжлийн эмч, нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 06 сарын 13-ны өдөр Баян-Өлгий, Увс, Ховд, Хөвсгөл 4 аймгууд хамтран зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан. Мөн Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүртгэлд тулгуурлан эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал шийдвэрийн хэрэгжилтэд цахим хяналт хийж, дотоодын дахин магадлал зохион байгуулах, магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоодын хяналтыг сайжруулах зорилгоор ижил мэргэжилтний үзлэгийг Сэлэнгэ аймагтай хамтран зохион байгуулж тайланг нэгтгэн, үр дүнг тооцон ажилласан. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн даргаар 2025 оны 03 сарын 20-ны өдөр батлуулсан төлөвлөгөөнийн дагуу даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэхдээ авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Аймгийн засаг даргын тамгын газрын хуульзүйн хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр ЭММЗ-ийн 9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гишүүнийг хамруулан зохион байгуулсан.<br>Мөн 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх Нийгмийн даатгалын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан цахим сургалтын бэлтгэл ажлыг ханган зөвлөлийн гишүүд 80 хувийн ирцтэй хамрагдсан.<br>Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 3053 | |
| 3.3.1.5 | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орои сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаатай болсон байна. | Нийгмийн даатгалын тухай хуулийн 29.1.Тэтгэврийн хуваарилалтын тогтолцоноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна гэж заасан байдаг. Уг заалтыг хэрэгжүүлэх дагалдах журам батлагдаагүй болно. | Хугацаа болоогүй |
| **3.3.2 Нийгмийн халамжийн талаар** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.2.1 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо- 55 бүлэг, 110 хүн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо: 5 | Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна. | ОНОТХҮ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулах тендерийг зарлаж Хармаг хулан ХХК, “Өсвөр үе ирээдүй увс төв” нийгэмд үйлчлэх ТББ, “Их хотол чуулган” нийгэмд үйлчлэх ТББ байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж 150 иргэнийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах сургалтад, бүлгийн төсөлд 45 бүлгийн 90 хүнийг хамруулан 158,6 сая төгрөг зарцуулсан.<br>Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр 30 иргэн хөдөлмөр эрхэлж байна. | хэрэгжсэн |
| 3.3.2.2 | Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх , донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхлэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо | - | Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл согтууруулах, мансууруулах, донтох өвчтэй иргэн, хорих ангиас суллагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээнд тендер шалгаруулалтыг зарлаж, шалгарсан “Хүн нэг бүрийн хөгжлийг дэмжих төв” нийгэмд үйлчлэх ТББ, Увс аймгийн цагдаагийн газрын ахмадын зөвлөл НҮТББ-тай гэрээ байгуулан ажиллаж 20 иргэнийг сургалтанд хамруулан 54 сая төгрөг зарцууллаа.<br>Дэмжих бүлгийн тоо-2 | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Архинаас гарсан иргэний тоо-6 Тогтмол ажлын байртай болсон хүний тоо-5 | |
| 3.3.2.3 | Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавжуулах сургалтад тогтмол хамруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо 2.Сургалтын тоо | Арга хэмжээний тоо-1 Сургалт-5 | Нийгмийн ажилтнуудын мэдлэг ур чадвар сайжирсан байна. | Сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн 126 гишүүнд байгууллагын үйл ажиллагаа сурталчлах, сумын нийгмийн ажилтантай хэрхэн хамтран ажиллах талаар мэдээлэл түгээх арга хэмжээг 18 суманд зохион байгууллаа. Нийгмийн ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж 180 албан хаагчийг хамрууллаа. Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумын 23 мэргэжилтэн буюу нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг танхимаар 3 удаа, цахимаар 4 удаа зохион байгууллаа. Сургалтаар харилцааны ур чадвар, сэтгэл зүйн эрүүл мэнд, стресс менежмент, төрийн албан хаагчийн манлайлал болон холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэг олголоо.<br>Үр дүн:<br>Арга хэмжээ-2, Сургалт-7 | хэрэгжсэн |
| **3.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3.1. | Хөгжлийн бэрхшээлтэй талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгө өөр | Сургалт | Арга хэмжээний тоо-54 Хүний тоо- 1300 | 30-аас доошгүй | Хөгжлийн бэрхшээлтэй талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалтыг нийт 48 удаа Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн хурал, ХБХЭМБНХСК -н хурлаар орж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эцэг эх, асран хамгаалагч 526 иргэнд хийсэн.  | хэрэгжсэн |
| 3.3.3.2 | Хөгжлийн бэрхшээлтэй талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгө өөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 20 | Монголын Хараагүйчүүдийн холбоо Увс аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран Увс аймгийн 19 сумын 114 байгууллагад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн талаарх сургалтыг зохион байгуулсан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Аймгийн ЗДТГазар НБХ, ХХҮГазар, ЭМГазар, БГазар, ХБИргэдийн төрийн бус байгуулагууд хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөгийг 2025 оны 12 дугаар сарын 11, 12-ны өдөр зохион | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. /2025 оны 12 дугаар сарын 03-ний өдөр төлөвлөсөн боловч аймгийн хэмжээнд ханиад томууны тархалт ихэссэнтэй холбогдуулан Улаангом сумын Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/375 дугаартай захирамжаар олон нийтийн үйл ажиллагааг хориглосон тул арга хэмжээний хугацаа хойшилсон./ | |
| 3.3.3.3 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 3 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд хамтран нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгаа болон зорилтот бүлгийн иргэдийн судалгааг гаргасан. **Үүнд:** 15-49 насны нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд-19.574 Үүнээс зорилтот бүлгийн 5.371 байгаагаас эрхтэн тогтолцооны эмгэгтэй-4.007, амьжиргааны түвшин доогуур-1.057, гэр бүлийн хүчирхийлэлтэй-117, сэтгэцийн өөрчлөлттэй-190 эмэгтэй байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн зөвлөгөө өгөх ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Бэлгийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургагчдын сургалт явуулах арга зүйг дээшлүүлэх" мэдлэгийн өртөө бүлгийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтанд 18 сумын эрүүл мэндийн төв, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн эх баригч, НЭМА нар нийт 35 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан. | |
| 3.3.3.4 | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Дэмжих төв | - | 1 | 2026-2028 ХБХ-ий эрх оролцоо, хөгжлийг дэмжих төсөл арга хэмжээг боловсруулан, 2025 оны 12 дугаар арын аймгийн ИТХ-ын хурлаар оруулан батлуулахад бэлэн болсон бөгөөд уг хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөнд ХБХ-ийн дэмжих төв байгуулахаар тусгагдсан. | Үнэлэх боломжгүй |
| 3.3.3.5. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар коммисын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Арга хэмжээний тоо-1 Хүүхдийн тоо - 132 Мөнгөн дүн- 8 сая | 2 | ХБХЭМБНСКомиссын хуралдааныг 20 удаа зохион байгуулсан. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд урьдчилан сэргийлэх үзлэгт 9 сартай 987 хүүхдээс 806, 18 сартай 945 хүүхдээс 718 хүүхэд, 36 сартай 958 хүүхдээс 703 хүүхдийг үзлэгт хамруулсан байна. Үр дүн: Урьдчилан сэргийлэх үзлэгт 9 сартай 81,7%, 18 сартай 75,9%, 36 сартай 73,4% хамрагдсан байна. Нийт хэрэгжилт 77% байна.<br>Эрүүл мэндийн төрөлжсөн тусламж үйлчилгээнд | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо– 360<br>Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо -356<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын байдлыг авч үзвэл 0-18 насны 489 хүүхдээс цэцэрлэгт 90 хүүхэд, сургуульд 199 хүүхэд хамрагдан суралцаж боловсролд хамрагдах 339 хүүхдээс 289 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж, хамрагдалт 85,3%-тай байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын ажилчдыг чадавхижуулах бүсийн сургалтад хамрагдсан.<br>Сэтгэц эрүүл мэндийн үндэсний төвийн эмч ирж ажиллаж 54 хүүхдийг үзэж оношилгоо хийсэнээс 7 хүүхэд аутизм, 1 хүүхэд оюуны хомсдолоор оношилогдож хөгжлийн бэрхшээлээ тогтоолгосон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  Зохион байгуулсан арга хэмжээ - 3 | |
| 3.3.3.6 | Орон нутгийн гамшгаас хамгаалах онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | 100 | Улаангом сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн Б.Энхмаатай хамтран “Гамшгийн тухай ойлголт” “Анхны тусламж” “Гал түймрийн тухай ойлголт” зэрэг сэвийн хүрээнд 8 иргэнд сургалт хийж зөвлөмж өгсөн. Аймгийн Улаан загалмайн хороотой байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэний асран хамгаалагч нарт гэнэтийн аюулт үзэгдлийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах талаар сургалт, мэдээлэл өгч гамшгийн үеийн нөхцөл байдалд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр зөвлөмж өгсөн.<br>Улаангом сумын 4, 5, 9, 12 дугаар багийн Засаг дарга нартай хамтран 4 багийн хөгжлийн бэрхшээлтэй 6 том хүн | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2 хүүхдэд ахуйн хэрэгцээний дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.<br>Мөн Орон нутгийн гамшгаас хамгаалах онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад тулгуурлан, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. | |
| 3.3.3.7. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийг талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Сургалт-1 | 5 | Аутизмтэй 15 хүүхдийн эцэг эхчүүдтэй хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийг талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн сургалтанд 40 иргэн, спортын нөхөрсөг 5 төрлийн тэмцээнд 60 иргэн, урлагын үзлэгийн арга хэмжээнд 22 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнд 20 гаруй иргэдийг хамруулан ажилласан. Өдөрлөгийн үйл ажиллагаанд 130 гаруй иргэн оролцсон.<br>Зохион байгуулсан арга хэмжээ - 5 | Хэрэгжсэн |
| 3.3.3.8. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн | Орон нутгийн | Гэрээ байгуулсан хамтран | - | 3 | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөө гарган, холбогдох байгууллагуудад албан бичиг | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах; | төсвийн хөрөнгөөр | ажилласан ТББ-ын тоо | | | илгээж, 49 байгууллагын судалгаа гаргаж нэгтгэлээ. Тус 49 байгууллагад 71 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, эрх зүйн зохицуулалтыг хангуулах тухай хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 12 заалт бүхий 02 дугаар зөвлөмжийг 150 аж ахуй нэгж, байгууллагад хүргүүлж ажиллалаа. Хөгжлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-144.3 дахь хэсгийн хүрээнд 14 аж ахуй нэгж, байгууллагын 420 гаруй албан хаагчдад сургалт мэдээлэл хийж, 3 төрлийн шторк бэлтгэж цахим сүлжээнд байршуулж сурталчиллаа.<br>ХЭДС-нд 1.6 сая төгрөг төвлөрүүлсэн. | |
| 3.3.3.9. | Орон нутгийн цахим хуудас телевиз нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цахим хуудасны тоо | - | 5 | Увс аймагт үйл ажиллагаа явуулдаг 2 телевиз /МВС, УВС/ болон идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 2 сайт /УВСЧУУД, УВСЫН МЭДЭЭ/ эдгээр орон нутгийн цахим хуудас, телевизүүдийн мэдээлэл хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй ойлгомжтой байхаар ярилцлага | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг текстээр давхар гаргаж мэдээллэдэг болсон. | |
| 3.3.3.10. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо. Хамтын ажиллагааг сайжруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хувь | - | 90 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх асран хамгаалагчдын уулзалт хэлэлцүүлгийг Хүүхэд гэр бүл хөгжлийн газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж, 50 гаруй иргэдийн хамруулан эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, сэтгэл зүй, боловролын талаарх мэдээллийг өгч ажилласан. Салбар байгууллагуудын хариуцсан мэргэжилтнүүд салбар комиссын хуралд оролцож өөрсдийн хариуцсан чиглэлээр төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 90<br>Боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гарган холбогдох байгууллагуудыг мэдээллээр хანган ажилласан. | Хэрэгжсэн |
| 3.3.3.11. | Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо | Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, | 3 | Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран аймгийн төвийн гудамж, зам талбай болон нийтийн үйлчилгээний байгууллагуудын орц, гарц, замын тэмдэг, гэрэлтүүлэг, налуу зам, шат, гарц зэрэгт орчны хүртээмжийн бодит нөхцөл байдалд үнэлгээ НДГ, | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв | | ХХҮГ, Улаангом сумын ЗДТГ-т хийсэн. Уг ажлын үр дүнд ОНЗСХ-өөр баруун 4 замаас-Улаанглом сумын ЗДТГазар хүртэлх төв зам дагуу явган хүний зам, нийтийн эзэмшлийн гудамж талбайн орчны хүртээмж сайжруулах ажлын даалгавар боловсруулагдсан. 2026-2028 ХБХ-ий эрх оролцоо, хөгжлийг дэмжих төсөл арга хэмжээг боловсруулан, 2025 оны 12 дугаар арын аймгийн ИТХ-ын хурлаар оруулан батлуулахад бэлэн болсон бөгөөд уг хөтөлбөрт 2026 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөөнд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төвийн хүртээжтэй болгохоор тусган төлөвлөсөн. | |
| 3.3.3.12. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах | - | Хөгжлийн төвийн тоо | - | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих төсөл, арга хэмжээнд 3 зорилт 11 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг хийж байгуулах ажлыг тусган 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн | Хугацаа болоогүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлуулсан. 2026 онд хэрэгжинэ. | |
| **3.3.4 Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:** | | | | | | | |
| 3.3.4.1 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох жендерт суурилсан хүчирхийлэл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл сурталчилгаа нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөл гэр бүлийн хөгжил хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1. Сургалт мэдээллийн тоо 2. Сурталчилгаа нөлөөллийн ажлын тоо | - | 5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна. | Жендерийн эрх тэгш байдлыг хангах, гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын албан хаагчдын мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалтыг 10 байгууллагад болон 11 сумын 1190 иргэнд зохион байгууллаа. Нийт сургалтын тоо-21 | Хэрэгжсэн |
| **3.3.5. Ахмад настны талаар:** | | | | | | | |
| 3.3.5.1 | Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2 | - | Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна. | Нийгмийн даатгалын газар, Гэр бүлийн хөгжил, хүүхэд хамгааллын газартай хамтран Ахмад настны тухай хуулийн танилцуулга, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний журам, шалгуур үзүүлэлт аргачлал зэрэг 116 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 3160 иргэнд зохион байгууллаа. Үүнээс: 19 сумын 31 багийн 1460 иргэн, 66 байгууллагын 757 албан хаагч, 747 ахмад, зорилтот бүлгийн 196 иргэн хамрагдлаа. | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.5.2. | Ахмадын сан байгуулан ажиллуулах тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах хяналт тавих | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо<br><br>Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо | Ахмадын сан 3, Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөтэй 8 байгууллага<br><br>- | ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна. | Аймгийн хэмжээнд Ахмадын сан байгуулсан байгууллага аймгийн /Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, УЦУОШТөв, Аймгийн Татварын газар,<br>Аймгийн хилийн цэргийн 0245 дугаар анги,<br>Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар,<br>Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс/<br>Нийт Ахмадын сан байгуулсан байгууллага тоо-6<br>Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллага /Аймгийн Татварын газар<br>Аймгийн хилийн цэргийн 0245 дугаар анги<br>Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар<br>Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс, УЦУОШТөв/ нийт-5 байна. | Хэрэгжээгүй |
| 3.3.5.3. | Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон өргөө байгуулах тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Баталсан төсвийн хэмжээ<br><br>Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо | 93.07 сая | 20-оос доошгүй хувьд хүрсэн байна.<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна. | 2025 онд Аймгийн ахмадын хорооны даргатай байгуулсан “төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх” гэрээг хийж ахмадын хороо нь 6 багц 34 ажил төлөвлөснөөс 34 ажил, арга хэмжээг хийж гүйцэтгэсэн.<br><br>Ахмад настны эрүүл мэнд боловсрол төсөл, арга хэмжээний эхний шатны | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нээлттэй байх талаар анхаарч ажиллах | | | | | хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд 2026 оны эхний улиралын аймгийн ИТХ-ын хуралдаанаар оруулахаар төлөвлөн бэлтгэл ажил хийгдэж байна. | |
| 3.3.5.4. | Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөжлмийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Үйлчилгээнд хамрагдсан тоо | - | Ахмадын үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна. | Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ, гэрийн асрамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулах тендерийг зарлаж Ахмадын хороо, Энжи сувилахуй ХХК-ыг шалгаруулан гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.<br>Идэвхтэй насжилтыг дэмжих зөвлөгөө өгөх үйлчилгээнд 600 гаруй ахмадын хамруулж 12 сая төгрөг, гэрийн асрамжийн үйлчилгээнд 40 гаруй ахмадыг хамруулж 25 сая төгрөг олгосон. | Хэрэгжсэн |
| 3.3.5.5. | Ахмад настны бие бялдар танин мэдэхүй сэтгэлзүй үйл ажиллагааны чадвар нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо | - | Ахмад настны бие бялдар танин мэдэхүй сэтгэлзүй үйл ажиллагааны чадвар нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна. | Геронтологийн үндэсний төвтэй хамтран АНЭ, өрх сумын эрүүл мэндийн 24 байгууллагын 50 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах багц цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтын үр дүнд суралцагчид цогц үнэлгээ хийх мэдлэг чадварыг эзэмшиж, ЭМС-ын А/22 тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн энэхүү тушаалын хүрээнд "Ахмад настны цогц тусламж үйлчилгээ үзүүлэх ICOPE үнэлгээг хийх аргачлал" сэдвээр 4 ӨЭМТ, Сагил, Давст СЭМТ- | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ийн эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад ажлын байрны сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, ажиллалаа.<br>ЭМЯ-аас аймаг бүрд “Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг”-ийг яаралтай байгуулан ажиллах үүрэг, чиглэлийн дагуу Аймгийн засаг даргын захирамжаар Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, Ахмадын хорооний төлөөллийг ороцуулсуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй “Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг”-байгуулан, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарт "Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль", “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, “Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг” байгуулсан АЗД-ын захирамж танилцуулах сургалтуудыг үе шаттай зохион байгуулж ажилласан.<br>Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын аяныг “Эрүүл, идэвхтэй насжилт” сэдвийн дор зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулах, "Ахмад настны тухай" хуулийг хэрэгжүүлэн АЗДТГ, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал бусад салбарын байгууллагуудтай хамтран ажиллах, эрүүл мэндийг дэмжих цогц үнэлгээ хийх ажлыг эхлүүлэх, нийгмийн байдлыг сайжруулах талаар хамтран ажиллах чиглэл ирүүлсний дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд албан тоотыг хүргүүлэн, тайланг нэгтгэн Геронтологийн үндэсний төвд явуулсан.<br>Аяны хүрээнд цогц үнэлгээ хийх ажлыг эхлүүлэх зорилгоор АНЭ-ийн ахмадын эмчтэй хамтран 4 өрх, 18 сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, НЭМА нарт "Ахмад настны цогц үнэлгээ хийх аргачлал"- сэдвээр цахим сургалт явуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. ЭМГазар аймгийн төвийн 4 ӨЭМТ-тэй хамтран эрүүл мэндийн цогц үнэлгээ хийх, сургалт сурталчилгаа, олон нийтэд сурталчлах ажлуудыг хамтран хийсэн.<br>Нийт аяны хүрээнд 4 ӨЭМТ, 18 СЭМТ 740 настныг эрүүл мэндийн цогц үнэлгээнд хамруулсан. | |
| 3.3.5.6. | Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж | Орон нутгий | Орон нутгийн | | Ахмад настанд үзүүлэх тусламж | Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг аймгийн Засаг | хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаа иргэн аж ахуй нэгж төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийгмийн ажилтныг мэргэшүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулах хяналт тавих | н төсвийн хөрөнгөөр | мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх<br><br>Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо | | үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна. | даргын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/524 дугаартай захирамжаар байгуулсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарт "Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль", "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, "Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг" байгуулсан АЗД-ын захирамж танилцуулах сургалтуудыг үе шаттай зохион байгуулж ажилласан. | |
| 3.3.5.7. | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутануудыг ахмад настанд технологийн, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо<br>2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо | - | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд боловсрол, урлаг соёл, спорт, эрүүл мэнд, төрийн захиргаа, ХАА-н чиглэлээр, 72 ахмадыг хамруулж 75,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. аймгийн Ахмадын хороо нь МЦНХ-ны Увс аймаг дахь салбар холбоо хамтарч тус аймгийн 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ХДС, Улаангом коллежийн болон ерөнхий боловсролын сургуулиудын оюутан, сурагчдын дунд "Миний нутаг-100 жил" сэдэвт ЭССЭ бичлэгийн цахим уралдааныг зарлаж, уралдаанд 20 гаруй оюутан сурагчид оролцсон. | Хэрэгжээгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 33 ахмадыг хамруулж, 36,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. | |
| 3.3.5.8. | Ганц бие орон гэргүй эсхүл түр байгуулах газарт байсан иргэн нас барсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах санхүүжүүлэх журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Журам баталсан эсэх Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/ | - | Журмыг аймгийн ИТХ-арр батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна. | 2025 онд оршуулах үйл ажиллагаа гараагүй болно. | Хэрэгжсэн |
| 3.3.5.9. | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй нэгж байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна, гэсэн заалтын | | 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж | - | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэхь хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 50-аас дээш ажилтантай төрийн болон төрийн өмчит газар, ААН байгууллагын судалгааг гарган, нийт 18 байгууллагад хуулийн хэрэгжилт хангаж ажиллах тухай зөвлөмж боловсруулж хүргүүлсэн. | Хэрэгжээгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих; | | байгаа ахмад настны тоо | | | | |
| 3.3.5.10. | Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажиллах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Тухайн жилийн ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төг/ | - | Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна. | Нэгдсэн судалгаа гараагүй. | Хэрэгжээгүй |

ТАНИЛЦСАН. ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Э.БААТАРСАН

НЭГТГЭН ТАЙЛАГНАСАН: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ТАМИР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН А.ЗОЛЗАЯА